



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 765

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 552.1 (таван зуун тавин хоёр сая нэг зуун мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануурын дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1. Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.3. Компани зайлшгүй шаардлагаар эргэлтийн хөрөнгийн дутагдлыг нөхөх шаардлагаар банкнаас авсан зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах;

2.4. “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж;

3. “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Б.Ариун-Эрдэнэ)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.1. Багануур хотыг хэрэглээний цэвэр усаар хангах, бохирдсон усыг цэвэрлэж зайлуулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагад дулааны эрчим хүч түгээх зөвшөөрөл олгож, дулаан түгээх төвүүдийг эзэмшүүлсэнтэй холбогдуулан дулааны эрчим хүч үйлдвэрлэгчид үүсч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Багануур-Ус” ОНӨААТҮГ-аас дулааны эрчим хүч түгээх үйл ажиллагаа болон эзэмшиж буй дулаан түгээх төвүүдийн хөрөнгийг дулаан үйлдвэрлэгч

123007354

36-r huraldaan.docx

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн эзэмшилд шилжүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлэх арга хэмжээ авах;

3.2.Эрчим хүчний яамнаас "Багануурын дулааны станц" Төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-нд заасны дагуу компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг сайжруулахад анхаарч, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлж ажиллах;

3.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3.4.Тухайн жилийн худалдан авалтыг төлөвлөхдөө агуулах дахь материалын үлдэгдлийг тооцож, олон жилийн насжилттай, ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгө, бараа материалуудыг мөрдөж буй журмын дагуу акталж устгах, ажлыг зохион байгуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1.6.-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-ийг хориглохоор заасныг мөрдөж ажиллах;

3.5.Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг нормд заасны дагуу барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд үзлэг шалгалтыг хийж хувийн хэргийн хөтлөлтийг сайжруулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.1-т заасны дагуу "...хувийн хэрэг хөтлөх" гэснийг мөрдөж ажиллах нь зүйтэй.

3.6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ТУЗ-ийн гишүүдэд үр дүнгийн шагнал урамшууллыг олгодог явдлыг таслан зогсоох;

4.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн
2023 дугаар тогтоолын хавсралт

ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эрх бүхий байгууллагын шийдвэргүй арилжааны банкнаас авсан зээл	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	400,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
2	Гүйцэтгэх захиралд хууль бусаар олгосон жилийн үр дүнгийн урамшуулал	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	5,054.00	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийн заалтыг мөрдөж ажиллах
3	Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол зөрчсөн	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	8,317.60	Төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
4	Хууль тогтоомж зөрчин ТУЗ-ийн гишүүнд олгосон үр дүнгийн шагнал	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	8,203.80	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн мөрдөж ажиллах,
5	Батлагдсан журмын дагуу худалдан авалтын төлөвлөгөөнд тусгалгүй хэрэгжүүлсэн арга хэмжээ	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	42,310.00	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах журмыг мөрдөж ажиллах
6	Алданги, торгуульд төлсөн үйл ажиллагааны бус зардал	Захирал Б.Ариун- Эрдэнэ Ерөнхий ня-бо Б.Ариунжаргал	88,248.50	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
Дүн			552,133.9 (таван зуун тавин хоёр сая нэг зуун гучин гурван мянга есөн зуу)	